



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ЦАГААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 11 сарын 12 өдөр

Дугаар А/178

Цагаан-Уул сум

Г Хөрөнгө зарцуулах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Багийн хөгжлийг дэмжих ажлын хүрээнд зургаан багийн иргэдэд хууль сурталчилах, сургалт сурталчилгаа, багийн Засаг дарга нарын 2021-2024 оны үйл ажиллагааны тайлан тавихад зориулж 6.000.000 (Зургаан сая) төгрөгийг зарцуулсугай.
2. Дээрх зардлыг хөтөлбөр, хөрөнгө оруулалтын арга хэмжээний, Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийн зардлаас гаргаж зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ш.Эрдэнэцэцэг), Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Оюунчимэг) нарт зөвшөөрсүгэй.
3. Холбогдох санхүүгийн анхан шатны баримтыг хуулийн дагуу бүрдүүлж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын нярав (Н.Алтангэрэл)-д үүрэг болгосугай.

ОРЛОГЧ ДАРГА



Н.АЛТАНБААТАР